



ХОВД АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН  
ТАМГЫН ГАЗРЫН ДАРГЫН  
ТУШААЛ

2021 оны 04 сарын 12 өдөр

Дугаар А/61

Ховд

Үнэлгээний хороо байгуулах тухай

Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 46 дугаар зүйлийн 46.1.1 дэх заалтыг үндэслэн ТУШААХ нь:

1. Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгө оруулалтаар Мэргэжлийн хяналтын газраас Бүсийн оношилгоо эмчилгээний төвийн чиглэлийн явган хүний зам, авто зогсоол байгуулах ажлын гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах үнэлгээний хороог дараах бүрэлдэхүүнтэй байгуулсугай.

Дарга:	Н.Ганзориг	- Аймгийн Засаг даргын Тамгын газрын Хууль, эрх зүйн хэлтсийн дарга
Гишүүдэд:	Б.Энхжаргал	- 3 дугаар цэцэрлэгийн арга зүйч
	Ч.Буянтогтох	- Төрийн бус байгууллагын төлөөлөл
	Ц.Нямдаваа	- Иргэний төлөөлөл
Нарийн бичгийн дарга:	Х.Дэмид	- Худалдан авах ажиллагааны албаны мэргэжилтэн

2. Үнэлгээний хорооны гишүүдээс ашиг сонирхолын зөрчилгүй гэдгээ илэрхийлэх, зөрчил үүссэн тухай мэдэгдэл авах, тендер шалгаруулалтыг хууль тогтоомжийн дагуу зохион байгуулан явуулж үр дүнг танилцуулахыг Үнэлгээний хороо /Н.Ганзориг/-нд даалгасугай.

3. Дээрх төсөл арга хэмжээний худалдан авах ажиллагаатай холбоотой бүх баримт бичгээр хадгаламжийн нэгж үүсгэхийг Үнэлгээний хорооны нарийн бичгийн дарга /Х.Дэмид/-д үүрэг болгосугай.

ДАРГА



Д.ЭНХБОЛД

02 0319